

Мэргэжлийн сургууль гэж юу вэ?

Мэргэжлийн сургууль гэдэг нь тодорхой ажил мэргэжил болон бодит тал барт шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшүүлэх зорилготой дээд боловсролын байгууллага юм. Их сургуулийн адил сургуулийн боловсролын тухай хуулиар тогтоогдсон албан ёсны сургалтын байгууллага бөгөөд практик мэргэжлийн боловсрол, мэргэжлийн техникийн сургалтыг явуулж, олон салбарт мэргэжилтэн бэлтгэдэг. Кумамото мужид Кумамото мужийн мэргэжлийн болон төрөлжсөн сургуулийн холбоонд харьяалагддаг нийт 33 мэргэжлийн сургууль байдаг бөгөөд эдгээр сургуулиуд нь олон салбарт мэргэшсэн мэргэжилтнүүдийг бэлтгэн гаргаж байна

Website

Кумамото мэргэжлийн сургуулийн PR сайт

URL : <https://kumasenkaku-pr.com>



Related links

Кумамото Гадаад иргэдэд нэгдсэн зөвлөгөө өгөх плаза

URL / <https://www.kumamoto-if.or.jp/plaza>



Кумамото мужийн гадаадын иргэдийг дэмжих төв

URL / <https://www.kuma-koku.jp/support-center/>



[Төлөөлөгчийн газар]

Ерөнхий Хуулийн Этгээд - Кумамото мужийн мэргэжлийн болон төрөлжсөн сургуулиудын нэгдсэн холбоо

Та Кумамотод суралцах талаар бодож байсан уу?



PROFESSIONAL TRAINING COLLEGES in KUMAMOTO



Гадаадаас Кумамотод суралцах


Кумамото мужийн хүн ам ойролцоогоор 1.7 сая бөгөөд төрөл бүрийн худалдааны болон соёлын байгууламжтай. Японы өмнөд хэсэг "Кюүшү" нутгийн төвд оршдог Кумамото нь ой мод, далай тэнгис хосолсон үзэсгэлэнт байгальтай бөгөөд арвин баялаг гүний устай тул "Усны хот" ч гэж нэрлэдэг. Амттай усаар хийгдсэн олон төрлийн шинэхэн хоол хүнс, уух зүйлс энд бий.

Мөн хот дотор трамвай, автобус зэрэг нийтийн тээврийн хэрэгсэл сайн хөгжсөн тул сургуульдаа явах, өдөр ту там зорчиход хялбар. Орон нутгийн хот учраас Токио, Осака зэрэг томоохон хотуудтай харьцуулахад амьжиргааны өртөг харьцангуй хямд бөгөөд гадаад оюутнуудад амьдрахад таатай орчин бүрдсэн байдаг.

Мөн худалдааны төв, номын сан, урлагийн музей, спортын байгууламж зэрэг амьдралд хэрэгцээтэй дэд бүтэц сайтай тул томоохон хотуудтай адил олон төрлийн туршлага хуримтлуулах боломжтой.

Байгаль, хот төгс хосолсон Кумамото нь зөвхөн сурахас гадна өдөр тутмын амьдралаа зугаатай өнгөрүүлэх боломжтой, гадаадаас ирж суралцахад тохиромжтой газар юм.

Цаашлаад томоохон хагас дамжуулагч үйлдвэрлэгчид Кумамотод үйл ажиллагаагаа эхлүүлснээр дэлхийн хэмжээний хагас дамжуулагч төхөөрөмжийн компани, үйлдвэрүүд Кумамотод төвлөрөөд байна. Кумамотод ажиллаж буй гадаадын ажилчдын тоо өмнөх оноос 25.5%-иар нэмэгдэж, түүхэн дээд үзүүлэлтэд хүрсэн.



【Гадаад оюутнууд туршлагаас сонсьё.】

Кумамотог яагаад сонгосон бэ?

Мьянмар багш надад хэлж өгсөн. Гоё байгальтай, амьдрахад таатай гэж сонссон.

Сургуулийн амьдрал ямар байна вэ?

Эхэндээ бага зэрэг санаа зовж байсан ч багш нар эелдгээр зааж, зөвлөж өгдөг учир одоо сэтгэл амар байна. Мөн олон орны найзуудтай танилцаж, харилцах боломжтой нь гоё санагддаг.

Кумамотод амьдарч үзээд ямар санагдаж байна?

Их нам гүм, тайван орчинтой тул сэтгэл уужуу сайхан байдаг. Нам гүм, амьдрахад таатай хот.

Таны ирээдүйн мөрөөдөл, зорилго юу вэ?

Сайн асаргааны мэргэжилтэн болохыг зорьж байна. Зөвхөн асуулагчид төдийгүй тэдний ар гэрийнхний итгэлийг хүлэсэн асаргааны мэргэжилтэн болохыг хүсэж байна. Мөн олон газар аар аялж, шинэ зүйлүүд үзмээр байна.

Кин Мян Ноэ Кяү

Улс	/	Мьянмар
Сургуулийн нэр	/	Кюүшюү төв сэргээн засах коллеж
Тэнхим	/	Асаргаа халамжийн тэнхим

Кумамотог яагаад сонгосон бэ?

Суралцахад ирэхийн өмнө Кумамото аяллаар ирж байсан ба Кумамото цайзыг үзээд их үзэсгэлэнтэй, сайхан санагдсан. Тэгээд Кумамото д япон хэл суръя гэж шийдсэн.

Сургуулийн амьдрал ямар байна вэ?

Багш нар эелдэг, хичээлээ ойлгож мэт заадаг. Бүгд бие биедээ тусалж, өдөр бүрийг үр бүтээлтэй өнгөрүүлж байна.

Япон ирэхийн өмнө санаа зовж байсан зүйл бий юу?

Сайн ярьж чадах эсэхдээ санаа зовниж байсан. Харин багш нар болон найзууд бүгд эелдэг, удаанаар ярьж өгдөг тул санаа зовох зүйлгүй болсон.

Таны ирээдүйн мөрөөдөл, зорилго юу вэ?

Сургуулиа төгсөөд Япон компанид ажиллах хүсэлтэй байна. Мөн япон хэлээ сайн эзэмшээд, япон хүмүүстэй илүү ойр дотно харилцаж чаддаг болмоор байна. Японы олон газраар аялж үзмээр байна.

Жан Жиң-буо

Улс	/	Хятад
Сургуулийн нэр	/	Кумамото YMCA академи
Тэнхим	/	Япон хэлний тэнхим

Кумамотог яагаад сонгосон бэ?

Байгаль, уул, гол мөрөн цогцолсон, сайхан газар. Амьдрахад их таатай ба Кумамотогийн хүмүүс эелдэг, найрсаг гэж сонссон.

Япон хэлийг яаж сурч байгаа вэ?

Өдөр бүр бага багаар суралцаж байна. Багш нараар хэлний дүрэм болон харилцан яриа заалгаж байна. Гэртээ япон олон ангит кино, анимэ үзэж хэлээ давтдаг.

Цагийн ажил хийж байгаа юу?

Бенто хийдэг газар цагийн ажил хийж байдаг. Эхэндээ жаахан хэцүү байсан ч, аяндаа дассан.

Таны ирээдүйн мөрөөдөл, зорилго юу вэ?

Ирээдүйд Кумамотод ажилламаар байна. Авто засварын чиглэлээр ажиллах хүсэлтэй байгаа. Тэгэхийн тулд япон хэлээ илүү хичээж сурна.

Докак Кои

Улс	/	Вьетнам
Сургуулийн нэр	/	Кумамото инженерийн мэргэжлийн сургууль
Тэнхим	/	Япон хэлний тэнхим

Сургуулийн амьдрал ямар байна вэ?

Анги доторх уур амьсгал маш дулаахан, багш нар эелдэг, хичээлээ сайн заадаг. Найзуудтай хамтдаа хөгжилтэй суралцаж байгаа.

Кумамотод амьдарч үзээд ямар санагдаж байна?

Байгаль, орчин нөхцөл сайтай, агаар маш цэвэрхэн. Ус нь амттай, эндэхийн хүмүүс бүгд найрсаг.

Яагаад энэ мэргэжлийг сонгосон бэ?

Японы эрүүл мэндийн байгууллагын хүлээн авах хэсэгт ажиллаж, өөртэйгээ ижил япон хэлээр чөлөөтэй ярьж чадахгүй гадаад өвчтөнүүдэд тус болохыг хүсэж байна.

Энд суралцах хүмүүст хандаж хэлэх зүйл байна уу?

Эхэндээ хэцүү санагдах үе гарах ч багш нар болон эргэн тойрны хүмүүстэй зөвлөлдөж, бага багаар урагшлахад болно. Сайн болох гэж хэсэг илүүтэй аливаа "оролдож үзэх" зориг гаргах нь хамгийн чухал. Японд амьдарч үзэж бодож байсан бол заавал ирж үзээрэй.

Ши Юй-Жиэ

Улс	/	Хятад
Сургуулийн нэр	/	Кумамото YMCA академи
Тэнхим	/	Эрүүл мэндийн бичиг хэргийн тэнхим

Кумамотог яагаад сонгосон бэ?

Непалд манай ойрхон амьдардаг байсан танил маань энэ сургуульд суралцаж байсан юм.

Кумамотод амьдарч үзээд ямар санагдаж байна?

Ногоон байгаль ихтэй нь Непалтай төстэй. Японд зам тээвэр өндөр хөгжсөн. Манай ойрхон олон үйлчилгээний газрууд байдаг тул юм худалдаж авахад амар байдаг.

Япон хэлийг яаж сурч байгаа вэ?

Сургуулийн хичээл их сонирхолтой. Байрандаа хааяа найзуудтайгаа япон хэлээр ярихыг хичээдэг.

Япон дахь амьдрал ямар байна?

Би бенто хийдэг газар цагийн ажил хийж байна. Багш болон найз нарын хамт зам талбайн цэвэрлэгээний ажилд оролцдог.

Таны ирээдүйн мөрөөдөл, зорилго юу вэ?

Миний ирээдүйн мөрөөдөл бол сувилагч болох. Харин одоо Японд асаргааны чиглэлээр суралцах хүсэлтэй байна.

Буда Маяа

Улс	/	Непал
Сургуулийн нэр	/	Кюүшү хэмжил зүйн мэргэжлийн сургууль
Тэнхим	/	Япон хэлний тэнхим

【Багшийн ярилцлага】



Сургуулийн нэр / Кумамото YMCA академи Япон хэлний тэнхим

Сасаки Юта

Сургуулийнхаа давуу талыг хуваалцана уу!

Хамгийн том давуу тал бол олон орноос оюутнууд ирж суралцдаг явдал юм. Оюутнуудад зөвхөн суралцагч бус харин хамтдаа оршин тогтнож буй нийгэмд хувь нэмрээ оруулах орон нутгийн нэг иргэн гэдэг утгаар ханддаг ба янз бүрийн харилцаа холбоо, сайн дурын үйл ажиллагааны боломжуудыг олгож, соёлын ялгаа, хамт оршин тогтнох үзэл баримтлалыг чухалчилдаг.

Гадаад оюутнуудын байр байдлын талаар

Хичээл бүр гайхалтай. Тэд хичээлд идэвхтэй шамдан суралцдаг ба нүдэн дээр илт сайжирч мэдрэгддэг. Оюутнууд Япон хэлний түвшин тогтоох шалгалтад тэнцэх болон төгсөх үедээ талархал илэрхийлэхээр ирэхэд нь багшийн хувьд их баярладаг ба аклын утга учрыг эндээс мэдрдэг.

Хичээл заахдаа та юунд илүү анхаардаг вэ?

Хичээлийг багш төвтэй болгохгүйн тулд хичээлийн үеэр оюутнууд аль болох ярих, оролцох боломжийг бий болгодог.



Student Voices

